



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ Нийслэл хотод 2015 онд 2.9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүний 4.5 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 95.5 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 2014 онтой харьцуулахад 34.8 хувиар буюу 1.6 их наяд төгрөгөөр буурчээ. Энэ онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос 74.3 хувиар, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ 29.8 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын бүтэц, санхүүжилтийн эх үүсвэрээр, оны үнээр

Эх үүсвэр	Хөрөнгө оруулалт, тэрбум төг			Хөрөнгө оруулалтын бүтэц, хувиар		
	2013 он	2014 он	2015 он	2013он	2014он	2015он
Бүгд	4778.0	4508.1	2937.6	100.0	100.0	100.0
Дотоод	2986.7	3998.3	2806.7	62.5	88.7	95.5
Улсын төсвийн хөрөнгөөр	413.9	17.3	7.9	8.7	0.4	0.3
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	239.6	197.8	215.6	5.0	4.4	7.3
Нийслэлийн төсөв	134.5	87.8	112.1	2.8	1.9	3.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	27.8	32.1	20.9	0.6	0.7	0.7
Нийслэлийн замын сан	15.5	24.1	21.2	0.3	0.5	0.7
Он дамжиж хийгдсэн хөрөнгө оруулалт	61.8	53.8	61.4	1.3	1.2	2.1
Бусад / ААНБ-уудын хөрөнгө оруулалт/	2333.2	3783.2	2583.2	48.8	83.9	87.9
Гадаад	1791.3	509.8	130.9	37.5	11.3	4.5
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	1791.3	509.8	130.9	37.5	11.3	4.5

Нийслэлд шинээр бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо 2015 онд 316 болж өмнөх онтой харьцуулахад 42.9 хувиар буурчээ.

Хүснэгт 2. Гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ын тоо, улс орноор

Д/д	УЛС	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	БНХАУ	430	344	179	301	190
2	БНСУ	121	101	73	100	43
3	Япон	35	39	15	16	14
4	ОХУ	34	21	14	18	13
5	Британи Виржини арал	67	36	2	14	6
6	Сингапур	31	34	17	15	6
7	АНУ	36	15	8	5	5
8	Бусад орнууд	172	180	109	85	39
	Бүгд	926	770	417	554	316

Шинээр бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн 60.1 хувийг БНХАУ, 13.6 хувийг БНСУ, 4.4 хувийг Япон улс, 4.1 хувийг ОХУ, үлдсэн хувийг бусад улс орнуудын аж ахуйн нэгж, байгууллагууд эзэлж байна.

Хүснэгт 3 . Гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ын тоо, эдийн засгийн салбараар

Д/д	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	Худалдаа, нийтийн хоол	865	686	374	384	233
2	Боловсруулах үйлдвэрлэл	-	1	-	7	5
3	Бусад	15	50	29	65	7
4	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар	22	19	-	10	10
5	Барилга угсралт, инженерийн байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	1	4	5	29	16
6	Аялал жуулчлал	6	-	2	8	12
7	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	-	-	-	4	3
8	Тээвэр	9	3	2	10	4
9	Банк, санхүүгийн үйлчилгээ	2	2	3	3	2
10	Мэдээлэл холбооны технологи	-	2	1	7	3
11	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	1	2	-	4	2
12	Үл хөдлөх хөрөнгийн зуучлал, түрээс	1	-	-	3	6
13	ХАА, газар тариалан, МАА	4	1	1	20	13
Бүгд		926	770	417	554	316

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР